

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

201. оны ... дугаар сарын ...-  
ны өдөр

Улаанбаатар хот

### ТАРИМАЛ УРГАМЛЫН ҮР, СОРТЫН ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

##### **1 дүгээр зүйл. Хуулийн зорилго**

1.1. Энэ хуулийн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр таримал ургамлын шинэ сорт бүтээх, сорих, нутагшуулах, шинэ сортын эрхийг хамгаалах, түүнийг ашиглах, таримал ургамлын удмын санг хамгаалах, хадгалах, ашиглах, үрийн тариалан эрхлэх, тарих үрийн чанарыг хянах, баталгаажуулах, үрийн худалдаа эрхлэх, үрийн нөөц бүрдүүлэх, зарцуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

##### **2 дугаар зүйл. Таримал ургамлын үр, сортын тухай хууль тогтоомж**

2.1. Таримал ургамлын үр, сортын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

##### **3 дугаар зүйл. Хуулийн хамрах хүрээ**

3.1. Энэ хууль нөхөн сэргээх зорилгоор үржүүлэх модлог ургамлын үр, суулгац үйлдвэрлэхтэй холбогдсон харилцаанд үйлчлэхгүй.

3.2. Таримал ургамлын үрийн нөөцөөс бусад хүнсний нөөц бүрдүүлэхтэй холбогдсон харилцаанд энэ хууль үйлчлэхгүй.

##### **4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёо**

4.1.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.2. “таримал ургамал” гэж Тариалангийн тухай хуулийн 16.2-т заасныг (*үр тариа, буурцагт ургамал, малын тэжээл, тосны ургамал, техникийн ургамал, төмс, хүнсний ногоо, мөөг, эмийн, цэцгийн болон гоёл чимэглэлийн ургамал, жимс, жимсгэнэ зэрэг хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа ургамлыг*);

4.1.3. “үр” гэж таримал ургамлын сортын нөхөн үржихүйн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглагдах амьд үр, суулгац, тарьц, хөврөл, ургал эрхтэнийг;

4.1.4. “үрийн тариалан” гэж Үрийн тариалангийн даатгалын тухай хуулийн 3.1.1-т заасныг;

4.1.5. “хянан баталгаа” гэж тариалсан үр нь тухайн сортын тодорхойлолтод заасан хэв шинж, цэвэршилтийг хангаж байгаа эсэх, хог ургамал, өвчин, хортон байгаа эсэхийг талбай дээр нь шалган тогтоох үйл ажиллагааг;

4.1.6. “тарих үрийн чанарын шинжилгээ” гэж холбогдох стандартад заасан хураасан үрийн цэвэршилт болон тарих үрийн чанарыг лабораторийн шинжилгээгээр шалган тогтоох үйл ажиллагааг;

4.1.7. “сортын цэвэршилт” гэж тухайн тариалсан сортын тодорхойлолтод заасан хэв шинжээ хадгалсан ургамлын тоог тухайн талбайд ургасан өөр таримал ургамал болон сортын тоонд харьцуулсан үзүүлэлтийг;

4.1.8. “сорт” гэж селекцийн аргаар бий болгосон, биологи, аж ахуй, удамшил, хэлбэр зүйн тогтвортой хэв шинжийг агуулсан нэг гарал үүсэлтэй бүлэг ургамлыг;

4.1.9. “нутагшсан сорт” гэж тухайн бүс нутагт биологи, аж ахуйн нийтлэг болон тодорхой хэв шинжээр шалгарч, тариалах сортын бүртгэлд бүртгэгдэн тариалангийн үйлдвэрлэлд нэвтэрсэн сортыг;

4.1.10. ”ирээдүйтэй сорт” гэж сорт сорилтын эхний дүнгээр биологи, аж ахуйн нийтлэг болон тодорхой хэв шинжээрээ нутагшсан сортоос давж байгаа, нутагшсан сортоор бүртгэгдээгүй боловч сортын баталгаажуулалтын зөвлөлөөс ирээдүйтэй гэж зөвшөөрсөн сортыг;

4.1.11. “сорт сорилт” гэж таримал ургамлын шинэ сортыг удам гарвалын хувьд хянаж баталгаажуулах, тариалангийн бүсэд хяналтын сорттой харьцуулан сорих замаар сонгон шалгаруулах, тариалах технологийг нь судлан боловсруулах зорилгоор турших үйл ажиллагааг;

4.1.12. “сортын зохиогч” гэж сортыг бүтээсэн, нээж илрүүлсэн, эсхүл сайжруулсан хүнийг;

4.1.13.“зохиогчийн эрх эзэмшигч” гэж зохиогчийн эрх авсан ажил олгогч, эсхүл сортын зохиогчийг;

4.1.14.“лицензийн гэрээ” гэж зохиогчийн эрх олгосон шинэ сортыг ашиглуулах болзолтойгоор сортын зохиогч болон шинэ сортыг ашиглах сонирхолтой этгээдийн хооронд байгуулах гэрээг.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ СОРТ СОРИЛТ, БАТАЛГААЖУУЛАЛТ**

### **5 дугаар зүйл. Сортын баталгаажуулалтын зөвлөл**

5.1. Шинээр бүтээсэн таримал ургамлын сортыг баталгаажуулах, түүнийг сорилтонд шилжүүлэх, сорилтын үр дүнг үндэслэн түүнийг нутагшсан, эсхүл ирээдүйтэй сортоор баталгаажуулах болон энэ хуульд заасан бусад чиг үүргийг орон тооны бус сортын баталгаажуулалтын зөвлөл (цаашид “сортын баталгаажуулалтын зөвлөл” гэх) гүйцэтгэнэ.

5.2.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн сортын баталгаажуулалтын зөвлөлийг байгуулж, түүний дүрэм, шинэ сортыг сорих, баталгаажуулах журмыг батална.

5.3. Сортын баталгаажуулалтын зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг энэ хуулийн ... дугаар зүйлд заасан үр, сортын агентлаг эрхлэн гүйцэтгэнэ.

### **6 дугаар зүйл. Үр, сортын агентлаг**

6.1.Монгол Улсад үр, сортын асуудал эрхэлсэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг (цаашид “үр, сортын агентлаг” гэх) ажиллана.

6.2. Үр, сортын агентлаг нь тариалангийн бүс бүрт сорт сорилтын үйл ажиллагаа эрхлэх төвтэй байна.

6.3.Үр, сортын агентлаг дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

6.3.1.Сортын баталгаажуулалтын зөвлөлөөр баталгаажсан таримал ургамлын шинэ сортын бүртгэл (цаашид “сортын жагсаалт” гэх) хөтлөх;

6.3.2. шинэ сортын сорилтыг зохион байгуулах;

6.3.3.сорт сорилтын төвийг удирдлага, арга зүйгээр хангах;

6.3.4.нутагшсан болон ирээдүйтэй сортын бүртгэл, мэдээллийн сан хөтлөх;

6.3.5.үр үйлдвэрлэгч, үрийн тариалангийн талбай болон үр үйлдвэрлэлийн бүртгэл хөтлөх, мэдээ, тайлан гаргах;

6.3.6.үрийн хангамж, хүрэлцээг тооцоолох, импортлох, экспортлох үрийн тоо хэмжээг тогтоох;

6.3.7.сорт соригчдод арга зүйн сургалт явуулж, гэрчилгээ олгох, сунгах, хүчингүй болгох, холбогдох бүртгэлийг хөтлөх;

6.3.8. энэ хуульд заасан бусад.

## **7 дугаар зүйл. Сорт сорилт**

7.1. Шинэ сортыг сорилтонд шилжүүлэх асуудлыг сортын баталгаажуулалтын зөвлөл шийдвэрлэнэ.

7.2. Сорилт хийх хугацаа 3-аас доошгүй жил байна.

7.3. Сорилтыг сорт сорилтын төвд хийнэ.

7.4. Сорилтыг төсвийн санхүүжилтээр хувийн хэвшлээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

7.5. Сорт сорилтын төв болон энэ хуулийн .3.-д заасан этгээд (цаашид “сорт соригч” гэх) дараахь үүрэгтэй:

7.5.1. тариалангийн бүсэд сортыг батлагдсан арга зүйн дагуу сорих;

7.5.2. сортын үр үржүүлэх;

7.5.3. сортын үр үржүүлэх болон тариалах технологийг боловсруулах;

7.5.4. үр үржүүлэгчид сортын үр үржүүлгийн технологийн талаар мэргэжлийн зөвлөгөө өгөх;

7.5.5. үр, сортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад улирал бүр ажлаа тайлагнах.

7.6. Шинэ сортыг сорихдоо түүний зохиогчийн зөвшөөрлийг авсан байна.

7.7. Энэ хуулийн .1-д заасан арга зүйг мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлснийг үндэслэн, сортын баталгаажуулалтын зөвлөл батална.

## **8 дугаар зүйл. Сорилтын үр дүнг баталгаажуулах**

8.1. Сорилтын үр дүнг үндэслэн Сортын баталгаажуулалтын зөвлөл тухайн сортыг нутагшсанаар, эсхүл ирээдүйтэйгээр батална.

8.2. Нутагшсан сортоор батлагдсан сортыг үр, сортын агентлаг дахь тариалах сортын жагсаалт (цаашид “тариалах сортын жагсаалт” гэх)-д оруулна.

8.3. Эхний сорилтын үр дүнг баталгаажуулахаар ирээдүйтэй сортыг дахин сорилтонд 1-2 жилийн хугацаанд шилжүүлэхээр сортын баталгаажуулалтын зөвлөл шийдвэрлэнэ.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ. ҮРИЙН АНГИЛАЛ, ҮЙЛДВЭРЛЭЛ, НӨӨЦ**

### **9 дүгээр зүйл. Таримал ургамлын үрийн ангилал**

9.1. Таримал ургамлын сортын нөхөн үржихүйн үе шатаас хамааруулан тухайн сортын үрийг дор дурдсанаар ангилална:

9.1.1. цөм үр;

9.1.2. торгон үр;

9.1.3. баталгаажсан үр (нэгээс тавдугаар үеийн үр);

9.1.4. эрлийз үр.

### **10 дугаар зүйл. Цөм үр**

10.1. Сорилтод, эсхүл үрийн аж ахуйд шилжүүлэх зорилгоор шинэ сортыг бүтээсэн зохиогч, эсхүл түүний хяналт дор эрдэм шинжилгээний байгууллагад анхан шатны үрийн материал болгон үржүүлсэн үрийг цөм үрд тооцно.

### **11 дүгээр зүйл. Торгон үр**

11.1. Батлагдсан арга зүй, үр үржүүлгийн бүдүүвчийн дагуу цөм үрийг үржүүлж, холбогдох стандартад заасан сортын болон чанарын шаардлага хангасныг эрх бүхий байгууллагаас тогтоосон үрийг торгон үрд тооцно.

## **12 дугаар зүйл. Баталгаажсан үр**

12.1. Батлагдсан арга зүй, үр үржүүлгийн бүдүүвчийн дагуу торгон үрийг үржүүлж, холбогдох стандартад заасан сортын болон чанараын шаардлага хангасныг эрх бүхий байгууллагаас шалгаж тогтоосон үрийг баталгаажсан үрд тооцно.

12.2. Баталгаажсан үрийг 1, 2, 3, 4, 5 дугаар репродукцийн үр гэж ангилна.

12.3. Баталгаажсан 1, 2 дугаар репродукцийн үрийг үрийн тариаланд ашиглана.

12.4. Баталгаажсан 3,4,5 дугаар репродукцийн үрийг тариалангийн үйлдвэрлэлд ашиглаж болно.

## **13 дугаар зүйл. Эрлийз үр**

13.1. Эх, эцэг сортын сайн шинж чанарууд нь нэгдүгээр үедээ давуу байдлаар удамшдаг гетерозисийн үзэгдэл дээр тулгуурлан бүтээсэн сортын үр нь эрлийз үр байна.

13.2. Эрлийз үрийн нэгдүгээр үеийн үрийг тариалангийн үйлдвэрлэлд ашиглана.

## **14 дүгээр зүйл. Үрийн тариаланд ашиглах үрэнд тавигдах шаардлага**

14.1. Нутагшсан сортын үрийг үрийн тариаланд ашиглана.

14.2. Үрийн тариаланд ашиглах үр нь цөм, торгон болон баталгаажсан үрийн 1, 2 дугаар үеийн үр байна.

14.3. Үрийн тариаланд ашиглах үр холбогдох хууль, захиргааны хэм хэмжээний акт, стандартад заасан тарих үрийн сортын болон чанарын шаардлага хангасан байна.

14.4. Тухайн таримал ургамлын үрийн хангамж хүрэлцэхгүй байгаа тохиолдолд баталгаажсан 3, 4, 5 дугаар үеийн үр, эсхүл ирээдүйтэй сортын үрийг үрийн тариаланд ашиглахыг үр, сортын агентлаг зөвшөөрч болно.

14.5. Тухайн таримал ургамлын үрийн дотоодын үйлдвэрлэл байхгүй, эсхүл илэрхий бага тохиолдолд өөрийн аж ахуйн хэрэгцээнд зориулан бүртгэгдээгүй сортын үрийг ашиглахыг үр, сортын агентлаг зөвшөөрч болно.

14.6. Үрийн тариаланд хорио цээрийн хяналтанд байгаа болон хорио цээртэй хог ургамал, өвчин, хортонд нэрвэгдсэн, эсхүл бүртгэгдээгүй сортын үрийг ашиглахыг хориглоно. **(Зөрчлийн хуульд газрыг хураах)**

## **15 дугаар зүйл. Үрийн үйлдвэрлэл**

15.1 Торгон, баталгаажсан болон эрлийз үрийн үйлдвэрлэлийг тухайн төрлийн үр үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий иргэн, хуулийн этгээд, эрдэм шинжилгээний байгууллага (цаашид “үр үйлдвэрлэгч” гэх) эрхэлнэ.

## **16 дугаар зүйл. Үр үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл авахад тавихад тавигдах шаардлага**

16.1. Үр үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлтэй иргэн, хуулийн этгээд, эрдэм шинжилгээний байгууллага дараахь шаардлагыг хангасан байна:

16.1.1. тусгайлсан үрийн тариалангийн талбайтай байх;

16.1.2. зориулалтын үр сортлогч техниктэй байх;

16.1.3. үрийн зориулалтын агуулахтай байх;

16.1.4. тусгайлсан зориулалтын үтрэмийн талбайтай байх;

16.1.5. үр үйлдвэрлэлийн чиглэлээр мэргэшсэн хүний нөөцтэй байх;

16.1.6. үрийн тариалангийн талбайд хөрсний шинжилгээ хийлгүүлж дүгнэлт гаргуулсан байх.

16.2. Цөм болон торгон үр үйлдвэрлэх эрдэм шинжилгээний байгууллагын дотоод хяналтын итгэмжлэгдсэн лабораторитой байна.

16.3. Үр үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлтийг энэ хуулийн ..-д заасныг нотлох баримт бичгийн хамт хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

16.4. Үр үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлд үр үйлдвэрлэгчийн нэр, хаяг, үйлдвэрлэх үрийн төрөл, үр үйлдвэрлэх бүс нутаг, хүчинтэй хугацаа зэргийг тусгана.

16.5. Үр үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.

### **17 дугаар зүйл. Үр үйлдвэрлэгч**

17.1. Тухайн төрлийн үр үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий иргэн, хуулийн этгээд, эрдэм шинжилгээний байгууллага Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6.1-д заасны дагуу холбогдох байгууллагад мэдээллээ хүргүүлэх ба үр, сортын агентлагийн үр үйлдвэрлэгчийн бүртгэлд цахимаар бүртгүүлсний дараа үйл ажиллагаагаа эхэлнэ.

17.2. Тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч нь өөрийн аж ахуйн хэрэгцээнд зориулан үр үйлдвэрлэдэг бол үр үйлдвэрлэгчийн бүртгэлд бүртгүүлэх шаардлагагүй.

17.3. Үр үйлдвэрлэгч дараахь үүргийг хүлээнэ:

17.7.1. үрийн тариалангийн үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн зохистой дадлыг нэвтрүүлснээ эрх бүхий хөндлөнгийн байгууллагаар баталгаажуулсан байх;

17.4.2. өөрийн үйлдвэрлэсэн үрийг үр, хорио цээрийн хяналтад хамруулах;

17.4.3. үрийн тариалангийн талбайд сортын хянан баталгааг хийлгэх;

17.4.4. үрэнд тарих үрийн чанар, аюулгүй байдлын аюулгүй үзүүлэлтийн шинжилгээ хийлгэх;

17.4.5. зохиогчийн эрхээр хамгаалагдсан сортын үр үржүүлэх бол сортын зохиогчтой энэ хуульд заасан лицензийн гэрээ байгуулах;

17.4.6. сортын болон чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан, гарал үүсэл, үйлдвэрлэсэн технологи нь тодорхой үрийг бусдад худалдах.

17.5. Үр үйлдвэрлэгч нь дараахь бүртгэл, тэмдэглэлийг хөтөлж, хадгална:

17.5.1. талбайн түүх хөтлөх;

17.5.2. ул мөрийн мөшгих бүртгэл хөтлөх

17.5.3. үрийн тариаланд хэрэглэсэн үрийн сортын нэр, хэмжээ, гарал үүсэл;

17.5.4. үйлдвэрлэсэн үрийн хэмжээ:

17.5.4.1. чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан үрийн хэмжээ;

17.5.4.2. чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй үрийн хэмжээ;

17.5.4.3. худалдан борлуулсан үрийн хэмжээ болон худалдан борлуулсан хувь хүн, хуулийн этгээдийн мэдээлэл;

17.5.4.4. энэ хууль болон холбогдох бусад хуульд заасан үүрэг.

17.6. Энэ хуулийн ... -д заасан мэдээ, мэдээллийг харьяалах сум, дүүргийн тариалангийн болон үрийн хяналтын асуудал хариуцсан албан тушаалтанд тариалалт хийсний дараа болон ургац хурааснаас хойш 1 сарын дотор хүргүүлнэ.

### **18 дугаар зүйл. Таримал ургамлын үрийн нөөц**

18.1. Монгол Улс таримал ургамлын үрийн аюулгүйн болон технологийн нөөцтэй байна.

18.2. Байгалийн гамшгийн улмаас тухайн жилд үрийн хангамж хүрэлцэхгүй болсон тохиолдолд тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг иргэн, хуулийн этгээдэд үр нийлүүлэх зорилгоор үрийн аюулгүйн нөөцийг бүрдүүлнэ.

18.3. Тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчид үрийн шинэчлэл хийх зориулалтаар үрийн технологийн нөөцийг бүрдүүлнэ.

18.4. Нутагшсан сортын үрээр үрийн аюулгүйн болон технологийн нөөцийг бүрдүүлнэ.

18.5. Таримал ургамлын үрийн аюулгүйн болон технологийн нөөцийн хэвийн үйл ажиллагааг үр, сортын агентлаг хангаж ажиллана.

18.6. Үрийн технологийн болон аюулгүйн нөөц бүрдүүлэх үр нь холбогдох эрх зүйн хэмжээний акт, стандартад заасан сортын болон чанарын шаардлага хангасан тухай үрийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлттэй байна.

18.7. Үрийн аюулгүйн болон технологийн нөөцийн хэмжээ, үрийн аюулгүйн болон технологийн нөөцийг бүрдүүлэх, хадгалах, зарцуулах, түүнд тавих хяналттай холбогдсон журмыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

#### **19 дүгээр зүйл. Үрийн тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих**

19.1. Үрийн тариалангийн үйлдвэрлэлд Тариалангийн тухай хуулийн 19.5.3-т заасны дагуу дэмжлэг үзүүлж болно.

### **ДӨРӨВДУГААР БҮЛЭГ. ТАРИХ ҮРИЙН СОРТ, ЧАНАРЫГ БАТАЛГААЖУУЛАХ**

#### **20 дугаар зүйл. Тарих үрийн сорт, чанарт тавих шаардлага**

20.1. Энэ хуульд заасан тариалах сортын жагсаалтад бүртгэгдсэн, талбайн хянан баталгаа хийгдсэн, тарих үрийн чанарын шаардлага хангасан тухай үрийн улсын байцаагчийн дүгнэлттэй үрийг тариалангийн үйлдвэрлэлд ашиглана.

20.2. Тарих үрийн сорт, чанарыг нэгдсэн арга зүй, нэг нэр томьёо болон нэг төрлийн тоног төхөөрөмж ашиглан тодорхойлно.

20.3. Тарих үрийн сорт, чанарын шаардлагыг холбогдох стандартад тусгаж хэрэгжүүлнэ.

#### **21 дүгээр зүйл. Үрийн сорт, чанарыг тодорхойлох**

21.1. Үрийн сорт, чанарыг үрийн тариалангийн талбайд хянан баталгаа хийх болон лабораторийн шинжилгээ хийж тодорхойлно.

#### **22 дугаар зүйл. Хянан баталгаа хийх**

22.1. Үрийн тариалангийн талбай бүрт хянан баталгааг хийлгэнэ.

22.2. Үрийн тариалангийн талбайд хянан баталгаа хийх журмыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

22.3. Хянан баталгааг агротехнологийн мэргэжилтэй, хянан баталгаа хийх мэргэшлийн үнэмлэх бүхий хянан батлагч хийнэ.

22.4. Хянан баталгаа хийхэд тухайн сортын зохиогчийг болон эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын төлөөллийг татан оролцуулж болно.

22.5. Хянан баталгаагаар дараахь үзүүлэлтийг тогтооно:

22.5.1. хянан баталгаа хийж байгаа үндсэн сортын болц, гүйцсэн ишний тоог;

22.5.2. өөр сортын хольцыг;

22.5.3. ялгахад төвөгтэй өөр таримлын хольцыг;

22.5.4. хорио цээртэй хог ургамлын хольцыг;

22.5.5. өвчин хортонд нэрвэгдсэн байдлыг;

22.5.6. сортын цэвэршилтийг;

22.5.7. үндсэн таримлын болц гүйцээгүй ногоон ишний тоог;

22.5.8. холбогдох стандартад заасан бусад.

22.6. Хянан батлагч хянан баталгааны дүнг холбогдох аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын байгууллагад тухай бүр хүргүүлнэ.

22.7. Хянан баталгааны дүнд үндэслэн тухайн үрийн тариалангийн талбайгаас хураасан ургацыг үрийн зориулалтаар ашиглах эсэх дүгнэлтийг үр, сортын байцаагч гаргана.

22.8. Үрийн тариалангийн талбайд хянан баталгаа хийхтэй холбогдон гарах зардлыг тухайн үр үйлдвэрлэгч хариуцна.

22.9. Хянан баталгааны дүнгээр үрийн тариалан нь энэ хуульд заасан шаардлага хангахгүй байгаа нь тогтоогдвол тухайн талбайгаас хураасан ургацыг тариалангийн үйлдвэрлэлд үрийн зориулалтаар ашиглахгүй байх шийдвэрийг холбогдох аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын байгууллага гаргана.

22.10. Хянан батлагч бэлтгэх сургалтыг хөдөө аж ахуйн чиглэлийн эрдэм шинжилгээний байгууллага холбогдох төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж, мэргэшлийн үнэмлэх олгоно.

22.11. Хянан батлагчийн бүртгэлийг үр, сортын агентлаг хөтөлнө.

22.12. Хянан баталгаа хийх мэргэшлийн чиглэл олгох сургалт зохион байгуулах, хянан батлагчийн мэргэшлийн үнэмлэх олгох, хүчингүй болгох, бүртгэл хөтлөхтэй холбогдсон журмыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

### **23 дугаар зүйл. Лабораторийн шинжилгээ**

23.1. Хянан баталгааны дүнгээр энэ хуулийн 22.5-д заасан шаардлага хангасан талбайгаас хураасан ургацын дээжинд лабораторийн шинжилгээ хийж тарих үрийн чанарыг хангаж байгаа эсэхийг тодорхойлно.

23.2. Мэргэжлийн хяналтын байгууллагын үр, сортын хяналтын байцаагч ургацаас дээж авч лабораторит илгээх ба лабораторийн шинжилгээний дүнд үндэслэн дүгнэлт гаргана.

23.3. Тариалангийн үйлдвэрлэлд ашиглах үрийн чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийг итгэмжлэгдсэн лабораторит шинжилнэ.

23.4. Дээжинд шинжилгээ хийх шинжээч нь агрономи, ургамал хамгааллаар мэргэшсэн байна.

23.5. Ургацаас дээж авч, лабораторийн шинжилгээнд илгээх, дүгнэлт гаргах үйл ажиллагааг мэргэжлийн хяналтын байгууллагын даргын баталсан журмын дагуу гүйцэтгэнэ.

23.6. Мэргэжлийн хяналтын байгууллага лабораторийн шинжилгээний дүнгээр цахим сан бүрдүүлж, нийтэд танилцуулна.

### **24 дүгээр зүйл. Үрийг тариаланд ашиглахыг зөвшөөрөх**

24.1. Үр, сортын байцаагч лабораторийн шинжилгээний дүнгээр сортын болон чанарын шаардлага хангасан үрийг тариаланд ашиглахыг зөвшөөрсөн акт үйлдэж холбогдох байгууллагад хүргүүлнэ.

## **ТАВДУГААР БҮЛЭГ.**

### **ҮРИЙН ХУДАЛДАА, ХАДГАЛАЛТ, ТЭЭВЭРЛЭЛТ**

#### **25 дугаар зүйл. Үрийн худалдаа, хадгалалт, тээвэрлэлт**

25.1. Үрийг хадгалах, тээвэрлэх, худалдах үйл ажиллагааг холбогдох стандартын шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлнэ.

25.2. Иргэн, хуулийн этгээд нь үрийн худалдаа эрхлэх талаарх мэдээллээ Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6.1-д заасны дагуу мэдээлсний үндсэн дээр эрхэлнэ.

25.3. Тээвэрлэж яваа, эсхүл шуудангаар илгээж байгаа үрийг хорио цээрийн үзлэгт заавал хамруулна.

25.4. Хүнсний ногооны бага савлагаатай /10 гр хүртэл/ ариутгасан үрэнд энэ хуулийн ...-д заасан шаардлага үл хамаарна.

25.5. Энэ хуульд заасан шаардлага хангаагүй үрийг худалдахыг хориглоно.

#### **27 дугаар зүйл. Үрийн импортын зориулалт**

27.1. Холбогдох олон улсын хорио цээрийн гэрээ, хэлэлцээр болон үндэсний хууль, стандартад заасны дагуу тарих үрийн сортын болон чанарын шаардлага хангасныг нотлох бичиг баримттай үрийг дараахь зориулалтаар импортоор оруулна:

27.1.1. судалгаа, туршилт, үзэсгэлэнгийн зориулалтаар;

27.1.2. тухайн таримал ургамлын нутагшсан сортын үрийн хангамж хүрэлцэхгүй болсон бол;

27.1.3. байгалийн гамшигаас улмааснутагшсан сортын тарих үрийн хангамж хүрэлцэхгүй болсон болирээдүйтэй сортын үрийг;

27.1.4. дотоодын үрийн үйлдвэрлэл байхгүй таримал ургамлын үрийг.

## **28 дугаар зүйл. Импортоор оруулах үрэнд тавигдах шаардлага**

28.1. Импортоор оруулах үр нь дараахь шаардлагыг хангасан байна:

28.1.1. үрэнд тухайн импортлогч улстай байгуулсан ургамлын хорио цээрийн хэлэлцээрийн дагуу мэргэжлийн хяналтын байгууллагаар хянан магадлааг хийлгэсэн байх;

28.1.2. үрэнд дагалдуулсан баримт бичигт заасан гарал үүсэл, чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийг Монгол Улсын эрх бүхий итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээгээр баталгаажуулсан байх;

28.1.3. импортлогч орны үр, сортын чанар, болон үрийн анги нь дотоодын лабораторийн үр, сортын чанар, ангитай нийцсэн байх;

28.1.4. үрэнд хүнд металл, пестицидийн үлдэгдэл, цацрагийн үзүүлэлтийг шинжлүүлсэн байх;

28.1.5. үрийг үйлдвэрлэсэн улс, хот, суурин, аж ахуйн нэгж, үтрэм агуулахын нэр, үрийн гарал үүсэл, сортын нэр, насжилт нь тодорхой байх.

28.2. Судалгаа, шинжилгээнийхээс бусад зориулалтаар шинэ сортын таримлын үрийг импортоор оруулах бол оруулж ирэхээс 3 сарын өмнө загвар дээжийг хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторит хамруулж урьдчилсан байдлаар үрийн сортын болон чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийн талаар үрийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулсан байна.

28.3. Энэ хуулийн ...-д заасан шинжилгээтэй холбогдсон зардлыг тухайн үр импортлогч иргэн, хуулийн этгээд хариуцна.

28.4. Дараахь үрийг импортоор оруулахыг хориглоно:

28.4.1. энэ хуульд өөрөөр заагаагүй бол тариалангийн үйлдвэрлэлд үрийн зориулалтаар ашиглахаар нутагшсан, эсхүл ирээдүйтэйгээр бүртгэгдээгүй сортын үрийг;

28.4.2. тухайн улсдаа баталгаажаагүй үрийг;

28.4.3. гадаад улсад ашиглахыг хориглосон, эсхүл ашиглах хугацаа нь дууссан үрийг;

28.4.4. сав, баглаа боодолгүй, химийн, эсхүл биологийн гаралтай бодис, цацрагаар ариутгасан үрийг;

28.4.5. энэ хуульд заасан бусад шаардлагыг хангаагүй үрийг.

28.5. Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангаж байгаа зарим төрлийн таримал ургамлын үрийн чанар, хангамжийг хадгалах зорилгоор шаардлагатай гэж үзвэл импортлохыг хориглох, хязгаарлахаар шийдвэрлэж болно.

## **29 дүгээр зүйл. Үрийн экспорт**

29.1. Судалгаа, шинжилгээ, сорт сорилтод хэрэглэхээс бусад зориулалтаар үрийн улсын байцаагчийн дүгнэлтгүй үрийг экспортлохыг хориглоно.

29.2. Экспортлох үрийн цуврал бүрээс дээж авч лабораторийн шинжилгээнд хамруулах үйл ажиллагааг тухайн экспортлогч улстай харилцан тохиролцсон олон улсын гэрээний дагуу хэрэгжүүлнэ.

## **30 дугаар зүйл. Судалгаа, шинжилгээ, үзэсгэлэнгийн зориулалтаар импортлох, экспортлох үрийн хэмжээ**

30.1. Судалгаа, туршилт, үзэсгэлэнгийн зориулалтаар импортлох, экспортлох үрийн дээд хэмжээг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.



### **31 дүгээр зүйл. Үр импортлох, экспортлох хилийн боомт**

31.1. Үрийг Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хяналт, шалгалтын тухай хуулийн ... заасан хилийн боомтоор импортолно.

### **32 дугаар зүйл. Үрийн импорт, экспортын хяналт-шалгалт**

32.1. Импортоор нэвтрүүлэх үрэнд тавих үрийн болон ургамлын хорио цээрийн хяналтыг холбогдох хуульд заасны дагуу эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ.

32.2. Үрийн импорт, экспортын мэдээг гаалийн мэдээнд нэр, төрлөөр тусгайлан зааж оруулна.

32.3. Үрийг импортлох, экспортлох үед баримтлах ургамлын хорио цээрийн хяналт, шалгалт хийхтэй холбогдсон нарийвчилсан харилцааг Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн тухай хуулиар зохицуулна.

### **33 дугаар зүйл. Үрийн чанарыг баталгаажуулах**

33.1. Үрийн худалдаа, хадгалалт, тээвэрлэлт, импорт, экспорт эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээд үрэнд дагалдуулсан гэрчилгээнд тусгасан тарих үрийн сортын болон чанар, аюулгүй байдлын шаардлагыг хангах үүрэгтэй.

33.2. Энэ хуулийн ...1-д заасан тарих сортын болон үрийн чанар, аюулгүй байдлын шаардлагыг хангаагүй үр худалдснаас үүдэн гарах хохирлыг тухайн чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч эрхлэгч иргэн, хуулийн этгээд хариуцна.

### **34 дугаар зүйл. Үрийн савалгаа, шошго**

34.1. Үрийг савлагаатайгаар жижиглэнгээр, эсхүлбөөнөөр худалдах ба савлах боломжгүй үр, суулгацыг савалгаагүйгээр худалдаж болно.

34.2. Үрийг савлагаатай худалдах, тээвэрлэхэд түүний савлагаа нь холбогдох стандартад заасан шаардлагыг хангасан шошготой байна.

34.3. Бөөнөөр савлагаагүйгээр худалдах, тээвэрлэхэд үрийн цуврал бүрт тухайн үрийн сортын нэр, гарал үүсэл, чанарыг харуулсан баримт бичгийг дагалдуулна.

34.4. Химийн, эсхүл биологийн гаралтай бодис, цацрагаар үрийг ариутгасан бол энэ талаарх мэдээллийг түүний сав, баглаа боодолд тусгана. Ариутгасан бодис, цацрагийн хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг анхааруулсан болон тухайн үрийг ашиглахдаа баримтлах дарааллыг харуулсан бичиглэлийг шошгонд тусгах ба холбогдох бичиг баримтыг дагалдуулна.

34.5. Хувиргасан амьд организмаас гаралтай үрийн шошгонд холбогдох хуульд заасан тэмдэг, тэмдэглэгээ, онцлох шинж тэмдэг болон аюулгүйн санамжийг шошгон дээр тусгах ба савлаагүй бол энэ талаарх бичиг баримтыг дагалдуулна.

34.6. Органик тариаланд ашиглах боломжтой үрэнд энэ хуулийн ... заасныг нэг адил баримтална.

34.7. Жимсний суулгацын баглаа, боодол энэ хуулийн .. заалтын шаардлагыг хангасан байна.

34.8. Үрийн шошго, дагалдах бичиг баримтад үржүүлэгч, эсхүл худалдагчийн нэр, сортын нэр, гарал үүсэл, үйлдвэрлэсэн, савласан болон дуусах огноо, үржүүлэх болон хадгалах нөхцөл, дээж авах хугацаа, хэрэглэх зорилго, арга, тоо хэмжээ болон хууль, стандартад заасан бусад мэдээллийг тусгана.

34.9. Үрийг дахин савалсан, сав баглаа, боодлыг өөрчилсөн бол энэ тухай шошго, дагалдах бичиг баримтад тусгах ба үрийн чанар, аюулгүй байдлын шаардлагыг дахин савласан, сав баглаа боодлыг өөрчилсөн этгээд хариуцна.

34.10. Үрийг худалдах, тээвэрлэхдээ түүний сав, баглаа боодол, шошго, дагалдах бичиг баримтад тухайн үрийн сортын нэр, гарал үүсэл, чанарын талаар худал мэдээлэл оруулах, эдгээрийн талаар худал мэдээллийг сурталчилах, олон нийтийн хэвлэл, мэдээллийн сүлжээгээр тараахыг хориглоно.

**ЗУРАВДУГААР БҮЛЭГ.**  
**ТАРИМАЛ УРГАМЛЫН ШИНЭ СОРТЫН ХАМГААЛАЛТ,**  
**ЗОХИОГЧИЙН ЭРХ**

**35 дугаар зүйл. Шинэ сортыг хамгаалах нөхцөл**

35.1. Дараахь шалгуурыг хангасан сортыг хамгаална:

- 35.1.1. шинэ байх;
- 35.1.2. ялгаатай байх;
- 35.1.3. жигдэрсэн байх;
- 35.1.4. тогтворжсон байх.

**36 дүгээр зүйл. Шинэ байх**

36.1. Мэдүүлэг гаргасан өдрийг хүртлэх дараахь хугацаанд шинээр бүтээсэн сортыг шинэ гэж үзнэ:

36.1.1. сортын үрийг зохиогчийн зөвшөөрөлтэйгээр арилжааны зорилгоор бусдад дамжуулаагүй;

36.1.2. Монгол Улсын нутаг дэвсгэрт нэг наст таримал ургамлыг 1 жилийн, жимсний мод болон бутлаг ургамлыг 6 жилийн хугацаанд тус тус арилжааны зорилгоор бусдад дамжуулаагүй бол.

36.2. Мэдүүлэг гаргасан өдрийг хүртлэх хугацаанд эрх бүхий төрийн байгууллагын захиалгаар гүйцэтгэн хүлээлгэн өгсөн, туршилт, судалгаа, селекцид ашигласан, гадаад, дотоодын үзэгслэнд оролцсон, үйлдвэрлэлийн сорилтонд оруулсан, үр үржүүлэх зориулалтаар бусдад дамжуулсан бол тухайн сортын шинэ байдал хадгалагдана.

**37 дугаар зүйл. Ялгаатай байх**

37.1. Шинээр бүтээсэн сорт нь мэдүүлэг гаргах үед Монгол Улсад сортын жагсаалтад бүртгэгдсэн, эсхүл арилжааны зориулалтаар үйлдвэрлэлд нэвтэрсэн сортоос нэгээс доошгүй шинжээр өөр байвал тухайн сортыг ялгаатай гэж үзнэ.

**38 дугаар зүйл. Жигдэрсэн байх**

38.1. Үржүүлгийн онцлогоос шалтгаалахгүйгээр ургалтын явцад тухайн сортын үндсэн шинжүүд жигд илэрч байвал түүнийг жигдэрсэнд тооцно.

**39 дүгээр зүйл. Тогтворжсон байх**

39.1. Сортын үндсэн шинжүүд нь дараагийн үе удамдаа бүрэн хадгалагдаж байгаа сортыг тогтворжсонд тооцно.

**40 дүгээр зүйл. Сортыг шинэ сортоор баталгаажуулах**

40.1. Сортын баталгаажуулалтын зөвлөл энэ хуулийн ..-д заасан нөхцлийг хангасан сортыг шинэ сортоор баталгаажуулна.

40.2. Шинэ сортыг таримал ургамлын удмын сангийн хадгаламжинд бүртгэнэ.

**41 дүгээр зүйл. Шинэ сортын баталгаажуулалттай холбогдуулан үр, сортын агентлагийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

41.1. Үр, сортын агентлаг сортыг баталгаажуулахтай холбогдуулан дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

41.1.1. шинэ сортын мэдүүлгийг хүлээн авах, шалгах, нийтэд зарлах, түр хамгаалалтын арга хэмжээ авах;

41.1.2. шинэ сортыг баталгаажуулах ажлыг зохион байгуулах, шинэ сортыг бүртгэх, нийтэд зарлах, нэгдсэн бүртгэл хөтлөх, цахим хуудаст байршуулах;

41.1.3. баталгаажуулсан шинэ сортын үр үржүүлэх, тарих технологи, бүс нутгийн талаар зөвлөмж гаргах;

41.1.4. ашиглагдаж байгаа сортын эдийн засгийн үр, ашигт дүн шинжилгээг жил бүр хийх, нийтэд мэдээлэх;

41.1.5. шинэ сортоор баталгаажуулахтай холбогдсон баримт бичгийг хадгалах.

## **ДОЛДУГААР ЗҮЙЛ. ШИНЭ СОРТЫН МЭДҮҮЛЭГ ГАРГАХ**

### **42 дугаар зүйл. Мэдүүлэг гаргах**

42.1. Шинэ сортын мэдүүлгийг зохиогч, түүнээс эрх шилжүүлэн авсан иргэн, хуулийн этгээд үр, сортын агентлагт гаргана.

42.2. Зохиогч нь бүтээсэн сорт бүрдээ мэдүүлэг гаргана.

42.3. Шинэ сортын мэдүүлэг нь өргөдөл, шинэ сортын тодорхойлолт, товч тайлбараас бүрдэх ба шаардлагатай бол өргөдөлд холбогдох зураг болон эрх бүхий байгууллагын магадлагааг хавсаргана.

42.4. Мэдүүлгийг монгол хэлээр гаргана.

### **43 дугаар зүйл. Мэдүүлгийг шалгах**

43.1. Үр, сортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага мэдүүлгийн бүрдлийг шалгах ба шаардлагатай бол бүтээгчээс нэмэлт материал шаардаж болно.

43.2. Шаардлагатай нэмэлт мэдээ, баримт материалыг зохиогч дурдсан хугацаанд гаргаж өгөх үүрэгтэй.

43.3. Мэдүүлгийг хүлээн авсан өдрөөс хойш 2 сарын дотор урьдчилсан шүүлтийг хийнэ.

43.4. Урьдчилсан шүүлтийн шаардлага хангасан сортын талаарх мэдээллийг 6 сарын турш үр, сортын агентлаг байгууллагынхаа цахим хуудаст байршуулна.

43.5. Урьдчилсан шүүлтийн хугацаанд няцаасан нотолгоо ирсэн, маргаан гарсан тохиолдолд зохиогчид мэдэгдэнэ.

43.6. Зохиогч мэдэгдэл авснаас хойш 1 сарын дотор энэ хуулийн ..-д заасныг няцаасан нотолгоо ирүүлээгүй бол мэдүүлгийг буцаана.

43.7. Зохиогчийн ирүүлсэн нотолгоог үндэслэлтэй гэж үзвэл шүүлтийн дүгнэлтийг үндэслэн зохиогчийн эрх олгож, сортыг шинэ сортын жагсаалтад бүртгэж, мэдүүлгийг нь шинэ сортын санд хадгална.

43.8. Урьдчилсан шүүлтийн хугацаанд няцаасан нотолгоо ирүүлээгүй бол үр, сортын агентлаг энэ хуулийн ..8-д заасныг хэрэгжүүлнэ.

### **44 дүгээр зүйл. Түр зуурын хамгаалалт**

44.1. Шинэ сортын мэдүүлэг гаргахаас эхлэн мэдүүлгийг нийтэд зарлах, зохиогчийн эрх олгох хүртэл хугацаанд зохиогчийн эрхийн түр зуурын хамгаалалтыг үр, сортын агентлаг авч хэрэгжүүлнэ.

44.2. Түр зуурын хамгаалалтын хугацаанд аливаа үйлдэл хийсэн этгээдээс зохиогчийн эрхийг эзэмшигч нөхөн олговор авна.

### **45 дугаар зүйл. Ургамлын шинэ сортын зохиогчийн эрхийн хүчинтэй байх хугацаа**

45.1. Зохиогчийн эрх олгогдсоноос хойш 20 жилийн хугацаанд уг эрх хүчинтэй байна. Жимсний мод болон бутлаг ургамлуудын хувьд энэ 25 жил байна.

## **НАЙМДУГААР БҮЛЭГ. ШИНЭ СОРТЫН ЗОХИОГЧИЙН ЭРХ**

### **46 дугаар зүйл. Шинэ сортын зохиогчийн эрх**

46.1. Шинэ сортын зохиогч дараахь эрх эдэлнэ:

46.1.1. шинэ сортоо өмчлөх;

46.1.2. эрхээ бусад этгээдэд шилжүүлэх;  
46.1.3. шинэ сортдоо нэр өгөх;  
46.1.4. шинэ сортын технологийн баримт бичиг боловсруулах, тэдгээрийг турших;

46.1.5. Шинэ сортыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, хяналт тавих; 40.1.6. шинэ сортыг ашиглаж олсон бусад этгээдийн орлогоос зохих хэмжээний төлбөр авах.

46.2. Шинэ сортыг хамтран бүтээсэн зохиогчид зохиогчийг эрхийг хамтран эдэлнэ.

46.3. Шинэ сортын мэдүүлэг болон техникийн баримт бичиг бүрдүүлэх, туршилт хийх зэргээр туслалцаа үзүүлсэн этгээдийг уг сортыг хамтран бүтээсэн зохиогч гэж тооцохгүй.

46.4. Шинэ сортыг хамтран бүтээсэн зохиогчид мэдүүлэгт зохиогчдын оролцооны хувь, эрхийг заах ба хэрэв заагаагүй бол энэ хуулийн ...1-д заасан эрхийг тэгш эдэлнэ.

46.5. Ижил шинэ сортыг тусдаа бүтээсэн бол хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад түрүүлж мэдүүлэг өгсөн огноогоор зохиогчийн эрх эдэлнэ.

46.6. Албан үүргээ гүйцэтгэх буюу гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх явцад бүтээсэн шинэ сортод зохиогчийн эрхийг гэрээнд өөрөөр заагаагүй бол ажил олгогч эдэлнэ.

46.7. Ажил олгогч шинэ сортыг бүтээснээс хойш 6 сарын дотор мэдүүлэг гаргаагүй бол зохиогч нь мэдүүлэг гаргах эрх эдэлнэ.

46.8. Энэ хуулийн ...7-д зааснаар зохиогч өөрийн нэр дээр эрх авсан тохиолдолд ажил олгогч тухайн бүтээлийг ашиглахдаа гэрчилгээ эзэмшигчид гэрээний үндсэн дээр зохих төлбөр төлнө.

#### **47 дугаар зүйл. Зохиогчийн зөвшөөрөл авах**

47.1. Зохиогч шинэ сортоо өмчлөх онцгой эрх эдэлнэ.

47.2. Бүртгэгдсэн шинэ сортыг зохиогчийн зөвшөөрлөөр ашиглана.

47.3. Шинэ сортыг ашиглаж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдах, хэрэглэх болон энэ зорилгоор хадгалах, гадаадаас оруулах бол зохиогчийн зөвшөөрлийг шаардана.

47.4. Зохиогч зөвшөөрөл олгохдоо нөхцөл, хязгаарлалт тавьж болно.

47.5. Энэ хуулийн ...1-д заасан үйл ажиллагааг зохиогчийн зөвшөөрөлгүйгээр хэрэгжүүлсэн бол зохиогч зөвшөөрөл авахыг шаардана.

47.6. Хамгаалагдсан шинэ сортоос гаралтай, эсхүл хураасан ургацыг шууд ашиглаж бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн бол зохиогч зөвшөөрөл авах боломжийг олгож болно.

47.7. Зохиогч энэ хуулийн ... заасан үйл ажиллагаатай холбоотой өөрийн эрхийг хангалттай хэрэгжүүлсэн гэж үзвэл зөвшөөрөл авахыг шаардахгүй байж болно.

#### **48 дугаар зүйл. Зохиогчийн эрхэд хамааруулахгүй нөхцөл**

48.1. Гэрчилгээ олгосон шинэ сортыг дараахь байдлаар ашиглавал зохиогчийн онцгой эрхийг зөрчсөн гэж үзэхгүй:

48.1.1. зохиогч өөрөө, эсхүл түүний зөвшөөрөлтэйгээр бусад этгээд зах зээлд гаргасан бүтээгдэхүүнийг ашиглах;

48.1.2. эрдэм шинжилгээ, сургалт, туршилтын ажилд ашиглах;

48.1.3. ашиг олох зорилгогүйгээр ашиглах.

48.2. Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхийн хамгаалалт хийгдсэн шинэ сортыг үр дүнтэй ашиглах зорилгоор шинэ сортын улсын нөөцийн сан бий болгоно.

#### **49 дугаар зүйл. Лицензийн гэрээ**

49.1. Сонирхогч этгээд зохиогчийн эрх олгосон шинэ сортыг ашиглах тохиолдолд зохиогчтэй лицензийн гэрээ байгуулна.

49.2. Лицензийн гэрээгээр зохиогч нь хамгаалагдсан сортыг ашиглах зөвшөөрлийг сорт ашиглагчид олгох, сорт ашиглагч гэрээгээр тогтоосон төлбөр төлөх болон гэрээгээр тодорхойлсон бусад үүрэг хүлээнэ.

49.3. Лицензийн гэрээнд дараахь зүйлийг тусгана:

49.3.1. шинэ сортыг ашиглах арга, хэлбэр, хэмжээ, хүрээ, хугацаа;

49.3.2. гэрээний талуудын эрх, үүрэг;

49.3.3. шинэ сортыг ашигласны төлбөрийн хэмжээ, түүнийг олгох журам;

49.3.4. гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээх хариуцлага;

49.3.5. маргаан шийдвэрлэх журам.

49.4. Лицензийн гэрээг бичгээр үйлдэх бөгөөд хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

49.5. Энэ хуулийн ...4-д заасан журмыг зөрчсөн гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

49.6. зохиогч өөрийн сортыг сонирхогч этгээдэд ашиглуулах лиценз олгох тухай хүсэлтээ хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргаж болно.

49.7. Лицензийн гэрээг шударга өрсөлдөөнийг хязгаарлах нөхцөлтэйгээр байгуулахыг хориглоно.

## **50 дугаар зүйл. Зохиогчийн эрх, лицензийн гэрээний хураамж**

50.1. Шинэ сортын мэдүүлэг гаргах, зохиогчийн эрхийг хүчинтэй байлгах, лицензийн гэрээг бүртгүүлэх хураамжийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад төлнө.

## **51 дүгээр зүйл. Сортын зохиогчийн эрхийн хураамж төлөх хугацаа**

51.1. Сортын зохиогчийн эрхийг хүчинтэй байлгах хураамжийг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасан хэмжээ, хугацаагаар төлнө.

51.2. Сортын зохиогчийн эрхийг хүчинтэй байлгах эхний 3 жилийн хураамжийг эрх олгох шийдвэр гарсан өдрөөс хойш 6 сарын дотор, дараахь хугацааны хураамжийг тухайн хугацаа эхлэхээс 6 сарын өмнө тус тус төлнө.

51.3. Хураамжийг энэ зүйлийн ...2-т заасан хугацаанд төлөөгүй бол хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн хугацаа өнгөрснөөс хойш 6 сарын хөнгөлөлтийн хугацааг тогтоож болох бөгөөд энэ тохиолдолд тухайн хугацааны хураамжтай тэнцэх хэмжээний төлбөр нэмж төлнө. */Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах/*

51.4. Зохиогчийн эрхийг хүчинтэй байлгах сонирхол бүхий этгээд зохиогчийн зөвшөөрлөөр хураамжийг төлж болно.

## **ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ. ШИНЭ СОРТЫГ НЭРЛЭХ**

### **52 дугаар зүйл. Сортыг нэрлэх**

52.1. Сортын зохиогч нь өөрийн бүтээсэн шинэ сортод нэр өгөх ба энэ нь тухайн сортыг тодорхойлох таних тэмдэг болно.

52.2. Тухайн сортын оноосон нэр нь тариалах сортуудын жагсаалтаас хасагдсан ч нэр нь хэвээр хадгалагдана.

### **53 дугаар зүйл. Сортын нэрэнд тавих шаардлага**

53.1. Сортын нэр нь дараахь шаардлагыг хангасан байна:

53.1.1. сортын нэрийг үг эсвэл үг тоогоор илэрхийлэх;

53.1.2. ижил болон төстэй зүйл ургамлын сортын нэрнээс ялгаатай байх;

53.1.3. сортын нэр нь сортын шинж чанар, үнэ цэнэ, өвөрмөц байдал, мөн чанарыг тусгасан давхардаагүй байх;

53.1.4. тухайн сортыг нэрлэхэд хэллэгийн хувьд тохиромжтой байх.

#### **54 дүгээр зүйл. Сортын нэрийг бүртгэх**

54.1. Зохиогч сортын нэрийншүүлт хийлгэхээр хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүсэлт гаргана.

54.2. Сортын нэр нь энэ хуулийн ..-т заасан шаардлагуудын аль нэгийг, эсхүл бүгдийг хангаагүй нь тогтоогдвол хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэрийг бүртгэхээс татгалзах ба зохиогчийг тогтоосон хугацаанд багтаж өөр нэрийн санал ирүүлэхийг шаардана.

54.3. Сортын нэрийг зохиогчийн эрхийг олгох үед бүртгэнэ.

#### **55 дугаар зүйл. Сортын нэр ашиглах**

55.1. Аливаа этгээд эрхээр хамгаалагдсан сортын үр худалдах, эсхүл зах зээлд гаргахдаа тухайн сортын нэрийг ашиглах үүрэг хүлээнэ.

55.2 Зохиогчийн эрх нь дуусгавар болсоны дараа ч энэ зүйлийн 1-д заасан шаардлага тавигдана.

55.3. Сортыг худалдах, эсхүл зах зээлд гаргахдаа худалдааны тэмдэг, худалдааны нэр, эсхүл эдгээртэй ижил төстэй бусад тэмдэглэгээг сортын нэрийн хамт ашиглаж болох ба сортын нэрийг харагдахуйц байдлаар байршуулна.

### **АРАВДУГААР ЗҮЙЛ. ЗОХИОГЧИЙН ЭРХИЙГ ЦУЦЛАХ БА ХҮЧИНГҮЙ БОЛГОХ, ХЯЗГААРЛАХ**

#### **56 дугаар зүйл. Зохиогчийн эрхийг цуцлах**

56.1. Дараах нөхцөл тогтоогдвол зохиогчийн эрхийг цуцалж, нийтэд зарлана:

56.1.1. зохиогчийн эрх олгох үед энэ хуульд заасан шаардлага хангаагүй нь тогтоогдвол; 56.1.2. зохиогчийн эрхийг зохих эрхгүй хүнд олгосон нь тогтоогдвол.

56.2. Энэ хуулийн 1-д зааснаас өөр бусад шалтгаанаар зохиогчийн эрхийг цуцалж болохгүй.

#### **57 дугаар зүйл. Зохиогчийн эрхийг хүчингүй болгох**

57.1. Энэ хуульд заасныг зөрчиж зохиогчийн эрх олгосон байвал хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх маргаан шийдвэрлэх комисс, шүүх зохиогчийн эрхийг хүчингүй болгоно.

57.2. зохиогчийн эрх эзэмшихээс, эсхүл зохиогчийн эрхийг хүчин төгөлдөр хадгалах хураамж төлөхөөс татгалзсан, эсхүл уг хураамжийг энэ хуулийн ....3 дахь хэсэгт заасан хугацаанд төлөөгүй бол зохиогчийн эрхийг хүчингүй болгоно.

57.3. зохиогчийн эрхийг хүчингүй болгох тухай хүсэлтийг эрх хүчинтэй байх хугацаанд зохиогч өөрөө гаргана. .

57.4. Энэ хуулийн ..1, ..2, ..3-т зааснаас д зааснаас өөр бусад шалтгаанаар зохиогчийн эрхийг хүчингүй болгохгүй.

57.5. Энэ хуулийн ..1, ...2, ..3-т заасны дагуу зохиогчийн эрх хүчингүй болсон бол хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шинэ сортын улсын бүртгэлд зохих өөрчлөлт оруулж, цахим хуудас дахь гэрчилгээний цахим хэвлэлд нийтэлнэ.

57.6. Хураамж төлөөгүй шалтгаанаар зохиогчийн эрхийг хүчингүй болгосон нөхцөлд зохиогчийн эрх хүчинтэй байх нийт хугацааны дотор зохиогчийн хүсэлтээр сэргээж болно.

#### **58 дугаар зүйл. Зохиогчийн эрхээ эдлэхийг хязгаарлах**

58.1. Энэ хуульд зааснаас бусад тохиолдолд нийтийн эрх ашгийг хамгаалахаас бусад шалтгаанаар зохиогчийн эрхээ бүрэн эдлэхийг хязгаарлаж болохгүй.

58.2. Энэ хуулийн ...1-д заасан шалтгаанаар зохиогчийн эрхийг хязгаарласан бол зохиогч нөхөн олговор авахаар шаардах эрхтэй.

## **59 дүгээр зүйл. Таримал ургамлын удмын сангийн хадгаламж**

59.1.Таримал ургамлын удмын санг арвижуулах, хадгалах, хамгаалах, селекцид ашиглах зорилгоор таримал ургамлын удмын сангийн хадгаламж байгуулна.

59.2.Таримал ургамлын удмын сангийн хадгаламж нь Монгол Улсын селекцийн болон нутгийн сорт, эрлийз, нутгийн дээж, гадаадын сортоос бүрдэнэ.

59.3.Таримал ургамлын удмын сангийн хадгаламж нь төрийн мэдэлд байх ба таримал ургамлын удмын сангийн судалгаа хийх, таримал ургамлыг цуглуулах, ангилах, шалгаж бүртгэх, хадгалах, өөрчилж шинэчлэх, ашиглах, солилцох асуудлыг таримал ургамлын селекцийн судалгааны хүрээлэн (цаашид “хүрээлэн” гэх) хариуцна.

59.4.Таримал ургамлын удмын сангийн хадгаламжинд байгаа тухайн үед тариалангийн үйлдвэрлэлд ашиглагдаж буй сортуудын нэгдсэн цахим каталогийг жил бүр нэмэлт, өөрчлөлтийг оруулан хүрээлэн цахим хуудастаа байршуулна.

59.5.Таримал ургамлын удмын сангийн судалгаа хийх, таримал ургамлыг цуглуулах, ангилах, шалгаж бүртгэх, хадгалах, өөрчилж шинэчлэх, ашиглах, солилцохтой холбогдсон журмыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

59.6. Таримал ургамлын удмын сангийн хадгаламжийн үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

59.7. Таримал ургамлын удмын сангийн хадгаламжид байгаа сортуудыг гадаад гаргах, гадаадын иргэн, хуулийн этгээд, байгууллагатай хамтран судалгаа хийх зориулалтаар ашиглах бол энэ тухай хүсэлтээ Монгол Улсад ашиг хуваах төлөвлөгөөний хамт хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

59.8. Гадаадын сортыг таримал ургамлын удмын сангийн хадгаламжинд хадгалуулахтай холбогдсон харилцааг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

## **АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХАРИУЦЛАГА**

### **60 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

60.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтанд Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

60.2.Энэ хуулийг зөрчсөн гэм буруутай иргэн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

60.3. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтанд Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

### **61 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

61.1.Энэ хуулийг 20..оны .. дугаар сарын ..-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.